

ӨГҮҮЛЭЛ

ОХУ-ын Үндсэн хуульд өөрчлөлт оруулахад нөлөөлсөн хүчин зүйлс, Үндсэн хуульд тусгалаа олсон байдал**Дамба-Очирын Туул**

Эрдэм шинжилгээний ажилтан,

ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн, Улаанбаатар, Монгол Улс

tuul_d@mas.ac.mn

Хураангуй: Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн өөрчлөлт нь төрийн эрх мэдлийн хуваарилалтад өөрчлөлт оруулах, ерөнхийлөгч болон парламентын эрх мэдлийг нэмэгдүүлэх, ОХУ-ын үндсэн хуулийг олон улсын гэрээ, хэлэлцээрүүдээс дээгүүр тавих, Төрийн Зөвлөлийн статусыг хуульчлах, тэтгэврийг индексжүүлэх, гэр бүлийн үнэт зүйлийг тодорхойлох гэсэн хэд хэдэн чиглэлээр дөч гаруй зүйл заалтыг хамаарч байгаа хэдий ч гол цөм нь одоогийн ерөнхийлөгчийн эрх мэдэл нэмэгдсэн, дахин ерөнхийлөгчид нэр дэвших эрхтэй болсон явдал гэж дэлхий нийт хүлээж аваад байгаа билээ. Иймээс энэ удаагийн Үндсэн хуулийн өөрчлөлт Оросын Холбооны Улсын нийгэм, улс төр, гадаад ба дотоод бодлогын ямар хүчин зүйлсээр хэрхэн нөхцөлдсөнийг шинжлэх, одоогийн ерөнхийлөгчийн анх дэвшүүлсэн анхны санал шинэ Үндсэн хуульд бодитоор хэрхэн тусгалаа олсныг авч үзэхээс гадна, ОХУ-ын улс төр, засаглалын тогтолцоо, хүн ам, нийгмийн харилцаанд тусах нөлөөг Оросын болон барууны улс төр, эрх зүйн чиглэлийн судлаачид хэрхэн тайлбарлаж буйг харьцуулан үзэх, судлаачийн зүгээс дүгнэхийг зорилоо.

Түлхүүр үгс: ОХУ, ОХУ-ын Үндсэн хуулийн өөрчлөлт, В.Путин, төрийн эрх мэдэл хуваарилалт, ерөнхийлөгчийн эрх мэдэл, Үндсэн хууль



Оросын Холбооны Улсын анхны Үндсэн хуулиас 2020 оны Үндсэн хууль хүртэл

Гучаад жилийн өмнө батлагдсан “Ельциний” гэгдэх Оросын Холбооны Улс (ОХУ)-ын шинэ Үндсэн хууль (ҮХ) нь ЗХУ задран унаснаас хоёр жилийн дараа, дотоодын улс төрийн гүнзгий хямралын үед 1993 оны 12 дугаар сарын 12-нд бүх нийтийн санал асуулгаар батлагдсан юм. Б.Ельцин ерөнхийлөгч байх хугацаанд ОХУ-ын субъектүүдийн нэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор зөвхөн 65-р зүйлд багахан өөрчлөлт оруулж байсныг эс тооцвол дорвитой нэмэлт өөрчлөлт орж байсангүй. 2000 онд В.Путин ерөнхийлөгчөөр томилогдсон дараа холбооны субъектүүдийн нэр солигдох, ОХУ-ын бүс нутгуудыг нэгтгэх үйл ажиллагаатай холбоотойгоор мөн энэ зүйлд хэд хэдэн удаагийн багахан өөрчлөлт оруулж байжээ.

В.Путин 2000 оноос хойш дараалан 2 удаа дөрвөн жилээр сонгогдоод байсан тул ОХУ-ын ҮХ-д зааснаар 2008 онд дахин нэр дэвших эрхгүй зохицуулалттай байв. Ингээд 2008 онд Д.Медведев (2008-2012) ерөнхийлөгчөөр сонгогдож, энэ албанд очсон жилдээ ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 4 байсныг 6 жил, Төрийн Думын бүрэн эрхийн хугацаа 4 байсныг 5 жил болгох, мөн Төрийн думын Засгийн газартай харилцах харилцаанд парламентын хяналтыг чангатгах тухай өөрчлөлтийг ҮХ-д оруулах санал гаргаж, 2008 оны 12

сард батлагдсан¹ нь анхны томоохон өөрчлөлт байсан юм.

Д.Медведевийн нэг удаагийн ерөнхийлөгчийн 4 жилийн бүрэн эрхийн хугацаа дуусч, 2012 онд В.Путин дахин энэ албанд ирэв. Ингээд 2014 онд ҮХ-д хэдхэн сарын зайтай хоёр удаа өөрчлөлт орсны эхнийхээр Арбитрын Дээд шүүхийг татан буулгаж, бүрэн эрхийг нь ОХУ-ын дээд шүүхэд шилжүүлсэн. Мөн төрийн тэргүүний эрх мэдлийг нэмэгдүүлэн, тэрээр ОХУ-ын субъектүүдийн ерөнхий прокурорын орлогч, прокуроруудыг томилох боломжтой болж байв. Дараагийн оруулсан өөрчлөлтөөр ерөнхийлөгч ОХУ-ын Холбооны Зөвлөлийн 10% хүртэлх гишүүдийг өөрийн зарлигаар шууд томилох эрхтэй² болсон.

Эдгээр өөрчлөлтөөс харахад, хэдийгээр цаг үеийн шаардлага, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн байж болох ч Ерөнхийлөгчийн эрх мэдэл нэмэгдсэн нь илт харагдаж байна. Нэгдүгээрт, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 6 жил болсон,

хоёрдугаарт, Холбооны Зөвлөлийг шүүд томилох хувь хэмжээ тогтоосон, прокуроруудыг томилдог болсон гэдэг нь шүүх эрх мэдэл тодорхой хэмжээгээр ерөнхийлөгчөөс хараат биш боловч хамааралтай болж эхэлжээ.

Одоо В.Путин 6 жилээр хоёр удаа

1 Госдума одобрила во втором чтении поправки Конституции Российской Федерации – с заседания Государственной Думы 19 ноября 2008 года. <http://duma.gov.ru/news/2046/>

2 Как менялась действующая конституция России. <https://tass.ru/info/7527629>

дараалан сонгогдоод энэ удаагийн бүрэн эрхийн хугацаа нь 2024 оны 5 дугаар сарын 7-нд дуусах юм. ОХУ-ын Төрийн Думын сонгууль 2021 онд, ерөнхийлөгчийн сонгууль 2024 онд болохтой холбоотойгоор 2019 оны сүүлээс Оросын болон барууны улс төрч, судлаачдын дунд Орост засгийн эрх ямар байдлаар, хэнд, хэрхэн шилжих тухай олон янзын хувилбар яригдаж байлаа. Эдгээр хувилбараас хэвлэл мэдээллийн хэрэгсэл, судлаачдын хүрээлэл дунд хамгийн өндөр магадлалтайд тооцогдож байсан нь Үндсэн хуульд өөрчлөлт оруулах, ингэхдээ ерөнхийлөгчид нэр дэвших эрхийн тухай заасан зүйл заалтад байгаа “дараалан”³ гэдэг үгийг авч хаях, мөн өөр нэмэлт зохицуулалт хийх тухай хувилбар байсан юм. Үүнийг зарим судлаачид хамгийн энгийнээр, Хятад Улс ҮХ-иа өөрчлөн, Коммунист нам Бүгд Хурлаараа баталж, намын удирдлагын албыг хаших хугацааг хязгааргүй болгосонтой адилтган, “хятад” хувилбар⁴ гэж нэрлэсэн нь ч бий. Мөн В.Путиныг ерөнхий сайд болох, эсвэл Төрийн Зөвлөлийн тэргүүнээр томилогдох хувилбар ч яригдаж байв. Гэхдээ одоогийн ерөнхийлөгч В.Путин засгийн эрхийг үргэлжлүүлэн барих гэсэн цорын ганц

шалтгаанаар энэ удаагийн өөрчлөлт хийгдсэн гэж шууд тодорхойлох нь өрөөсгөл юм. Иймээс ерөнхийлөгчийн Илгээлтэд хэлсэн үгийг задалж, үндэслэлийг тэрээр хэрхэн тодорхойлж, улс орны бодит хэрэгцээ, шаардлага, нөхцөл байдлыг дүгнэснийг авч үзэх нь зүйтэй юм.

В.Путин 2020 оны Илгээлтэдээ хүн ам зүй, боловсрол, эрүүл мэндийн салбар, шинжлэх ухаан ба технологийн салбарын хөгжлийн шаардлага, гадаад ба дотоод бодлого гээд тулгамдаад буй асуудлуудын өнөөгийн бодит байдлыг нарийвчлан тодорхойлоод, тухайн жилд анхаарч хийж гүйцэтгэх шаардлагатай ажлын чиглэлүүдийг тодорхойлсон. Илгээлтийн хамгийн их анхаарал татсан сэдэв бол ОХУ-ын ҮХ-ийг өөрчлөх хэрэгцээ шаардлагыг дурдаж, өөрийн зүгээс оруулах саналуудыг дэвшүүлэн, үндсэн хуулийн өөрчлөлтийн талаарх “хэлэлцүүлгийг эхлүүлж, тодорхой чиглэл гаргаж өгөхийг зорьсноо”⁵ илэрхийлсэн явдал байлаа. Харин улс төрч судлаачдын хүлээлтийг үүсгээд байсан ерөнхийлөгчид нэр дэвшигчийн талаар ямар нэг бодитой санал хэлээгүй юм. Ингээд өөрчлөлт хийхэд нөлөөлсөн байж болох хүчин зүйлсийг хэрхэн тодорхойлсныг дараагийн хэсэгт авч үзье.

3 “Одно и то же лицо не может занимать должность Президента Российской Федерации более двух сроков подряд” - ОХУ-ын Ерөнхийлөгчийн албыг нэг этгээд хоёроос олон удаа дараалан хашиж болохгүй (Судл.). ҮХ-ын 3 дугаар бүлгийн 81 дүгээр зүйл.

4 Три сценария власти в России: прогноз Екатерины Шульман 2019.12.13. <https://www.dw.com/ru/%D1%82%D1%80%D0%B8-%D1%81%D1%86%D0%B5%D0%BD%D0%B0%D1%80%D0%B8%D1%8F-%D0%BF%D0%B5%D1%80%D0%B5%D0%B4%D0%B0%D1%87%D0%B8-%D0%B2%D0%BB%D0%B0%D1%81%D1%82%D0%B8-%D0%B2-%D1%80%D0%BE%D1%81%D1%81%D0%B8%D0%B8-%D0%BF%D1%80%D0%BE%D0%B3%D0%BD%D0%BE%D0%B7-%D0%B5%D0%BA%D0%B0%D1%82%D0%B5%D1%80%D0%B8%D0%BD%D1%8B-%D1%88%D1%83%D0%BB%D1%8C%D0%BC%D0%B0%D0%BD/a-51656691>

5 Послание Президента Федеральному Собранию. 15 января 2020 года, 13:15, Москва. <http://kremlin.ru/events/president/news/62582>

Үндсэн хуульд өөрчлөлт оруулахад нөлөөлсөн хүчин зүйлс

В.Путин Илгээлтдээ зарим улс төр, нийгмийн хүрээнийхний дунд халуун сэдэв болж ирсэн “шинэ үндсэн хууль” батлах тухай санааг дурьдаад, цоо шинэ хууль батлах шаардлагагүй, тодорхой харин хэд хэдэн өөрчлөлт хийх зайлшгүй хэрэгцээ тулгараад буйг цохон тэмдэглэсэн. Хэдийгээр гучаад жил өнгөрсөн хэдий ч өмнөх үндсэн хуулиар тодорхойлсон үнэт зүйлс утга учиртай хэвээр тул улс орны одоогийн

нөхцөл байдалтай үндсэн хуулиа уялдуулан өөрчлөх нь зүйтэй гэж В.Путин үзжээ. В.Путин Илгээлтдээ Орос Улсад ҮХ-ийг өөрчлөх зайлшгүй шаардлагатай хэмээн 7 асуудлыг дэвшүүлсэн. Дурдсан долоон асуудлыг задалж үзээд Үндсэн хуулийг өөрчлөхөд нөлөөлсөн дотоод ба гадаад хүчин зүйлс хэмээн хоёр хэсэг болгон багцалж, ангилав. Үүнд:

Дотоод хүчин зүйл	Гадаад хүчин зүйл
1. Төрийн дээд албан тушаалтнуудад тавигдах шаардлагыг өндөржүүлэх; 2. Нутгийн өөрийн удирдлагын засаглалыг шинэчлэх; 3. Төрийн Зөвлөлийн үүрэг, статусыг Үндсэн хуулиар хуульчлах 4. Тэтгэвэр, цалингийн доод хэмжээг Үндсэн хуулинд индексжүүлэх 5. Парламентийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, Ерөнхийлөгчийг хүчирхэг хэвээр байлгах, засаглалын хуваарилалтыг эргэж харж шинэчлэх 6. Шүүх засаглалын хараат бус байдлыг сайжруулах.	7. ОХУ-ын ҮХ-ийг олон улсын гэрээ хэлэлцээрээс дээгүүр тавих. ОХУ дэлхийн бодлогод эргэн ирж, иргэдийн нийгмийн эрх, үндэсний эдийн засгийг гадны дарамтаас хамгаалах

1. Дотоод хүчин зүйл: Дотоодын улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын асуудлууд. В.Путин Илгээлтийн эхний хэсэгт хөндсөн дотоодын хүн амзүйн хямрал, боловсрол, шинжлэх ухаан, эрүүлийг хамгаалахын салбарын асуудлуудыг хөндөж, “үндсэн хуульд хэд хэдэн засварыг оруулах нь иргэний эрх, эрх чөлөө, тэдний сайн сайхан амьдралыг үнэт зүйлээ болгодог эрх зүйт төрт улс болох Оросын цаашдын

хөгжил цэцэглэлтэд нэн чухал”⁶ гэж үзэж буйгаа илэрхийлсэн. Үүнээс харахад шийдэгдэж урагшлахгүй байгаа нийгмийн олон нарийн асуудлын уг цаад шалтгаан нь ОХУ-ын ҮХ-д байна гэж үзэхээр байгаа тул өөрчлөлт оруулах шаардлагатай, ингэж байж улс орны тэргүүн зорилго болох нийт хүн амын амьдралын чанар сайжирч, хөгжил цэцэглэлт хурдтай явагдах ажээ.

6 Мөн тэнд

2. Гадаад хүчин зүйл: Гадаад аюулгүй байдлын асуудал. В.Путин “нийслэл Москва хотод 90-ээд оны эхэнтэй адил зэвсэгт мөргөлдөөнгүй, Умард Кавказад олон улсын терроризмын аюул үгүй болсон”⁷ тухай дурьдсан нь аюулгүй байдлын хувьд нөхцөл байдал харьцангуй сайжирч байгаатай, мөн ОХУ-ын барууны улсуудтай харилцах харилцаа, өрнөдийн улсуудын хориг, Крымын асуудлуудтай холбоотой байж болох талтай.

Харин ҮХ-д өөрчлөлт оруулах гол шалтгааныг улс төрч, судлаачдын таамаглаж байсан “нэг хүн дараалах, эс дараалах” тухай, нэмэлт зохицуулалт хийх тухайд В.Путин тун ч “бүрхэг”⁸ утгатай зүйл хэлээд орхисон. Тодруулбал: дараалах, эс дараалах гэдэг бол тийм ч чухал асуудал биш, гэхдээ дараалахгүй байх ёстой гэдэгтэй санал нэг байна гэсэн утгатай үг хэлсэн.

Үүнээс харахад, Орос дотоод асуудлаа шийдвэрлэхэд засаглалын эрх мэдэл хуваарилалтыг өөрчлөх, шинэчлэх зайлшгүй шаардлага тулгараад байгаа гэж үзэхээр байна. Аливаа улсын гадаад бодлого нь дотоод бодлогын үргэлжлэл байдаг тул

эхлээд дотоодын тулгамдаад байгаа асуудлаа шийдвэрлэх нь чухал. Улмаар дэлхийн бодлогод “эргэн ирэх” тухай дурдсан нь Хүйтэн дайны үед дэлхийн бодлогыг тодорхойлж байсан ЗХУ-ын түвшинд хүрэх зорилго тавих, олон улсын харилцаа, бусад улсуудтай дэлхийн бодлогыг тодорхойлох ашиг сонирхлын үүднээс харилцаагаа үндсэн хуулиар баталгаажуулахаа илэрхийлсэн болов уу.

Харин оросын сөрөг хүчний талыг баримтлагсад, барууны хэвлэл мэдээллийн хэрэгсэл, судлаачдын байр суурь ихэвчлэн В.Путиныг 2024 оны сонгуулийн дараа нэг бол ерөнхийлөгчөөр үлдэх⁹, эсвэл Төрийн Зөвлөлийн¹⁰ даргаар томилогдон эрх мэдлээ хэвээр хадгалж үлдэх¹¹ зорилготой хэмээн тайлбарлаж, “мөнхийн ерөнхийлөгч”¹² гэх нэршил хүртэл германы хэвлэлүүдэд гарсан юм. Ингэж байтал Илгээлтэд бараг дурьдагдаагүй шахуу өнгөрсөн ерөнхийлөгчид нэр дэвших тухай зүйл заалтыг өөрчлөх санал Төрийн Думд орж ирэв. ҮХ-ийн энэ заалтад өөрчлөлт оруулах саналыг анхны төсөл боловсруулснаас хоёр сарын дараа, парламентийн 3 дахь удаагийн хэлэлцүүлэг дээр, уг төсөл

7 Мөн тэнд

8 “... ОХУ-ын ерөнхийлөгчийн албыг нэг хүн хоёроос олон удаа дараалан хашиж болохгүй гэсэн үндсэн хуулийн заалт нийгэмд яригдаж байна. Үүнийг зарчмын асуудал гэж бодохгүй байна, гэхдээ үүнтэй санал нэг байна” Послание Президента Федеральному Собранию. 15 января 2020 года, 13:15, Москва. <http://kremlin.ru/events/president/news/62582>

9 https://www.kommersant.ru/doc/4302515?from=doc_yrez

10 ОХУ-ын Төрийн Зөвлөл нь 2000 онд анх ерөнхийлөгч В.Путины санаачлагаар байгуулагдсан бөгөөд төрийн аливаа бодлого боловсруулах, шийдвэрлэх эрх мэдэл хэрэгжүүлдэггүй, үүрэггүй, зөвхөн хэлэлцэн зөвлөлдөх үүрэгтэй байгуулага юм.

11 Russian Premier Abruptly Quits Amid Swirl of Speculation on Putin, Jan. 15, 2020 <https://www.nytimes.com/2020/01/15/world/europe/medvedev-putin-russia.html>

12 Russlands Präsident könnte bis 2036 im Amt bleiben. <https://www.tagesspiegel.de/politik/der-ewige-putin-russlands-praesident-koennte-bis-2036-im-amt-bleiben/25968790.html>

парламентаар батлагдахаас ганцхан хоногийн өмнө буюу 3 дугаар сарын 10-нд Думын гишүүн Валентина Терешкова гаргасан. Тэрээр “ирээдүйн ерөнхийлөгч дараалах, эс дараалахаас үл хамаарч зөвхөн хоёр удаа энэ албыг хаших бөгөөд энэ журам одоо алба хашиж буй ерөнхийлөгчид хамаарахгүй”¹³ гэж нэмэлтээр оруулж ирсэн.

Энэ нэмэлт Орост ч, гадны

Үндсэн хуулийн өөрчлөлтүүд (2020)

ОХУ нь ҮХ-ийн өөрчлөлтүүдийг багцлан, 2020 оны 6 дугаар сард бүх нийтийн санал асуулга явуулж, 77,9 хувийн дэмжлэгтэйгээр батлан, хууль 7 дугаар сараас хүчин төгөлдөр үйлчилж эхлэв. ОХУ-ын холбооны тогтолцоо, төрийн эрх мэдлийн тогтолцоог тодорхойлдог 3-8 дугаар бүлгүүдийн нийт 44 зүйлд өөрчлөлт оруулсан. Харин ОХУ-ын ҮХ-ийн тогтолцооны үндэсийг тодорхойлсон 1 дүгээр бүлэг, хүний эрх, эрх чөлөөний асуудлыг тодорхойлдог 2 дугаар бүлэг, ҮХ-ийн өөрчлөлт ба ҮХ-ийг эргэн харах тухай 9 дүгээр бүлгийг энэхүү өөрчлөлтөөр хөндөөгүй юм. Доорх графикт шинэ Үндсэн хууль хэлбэрийн хувьд хэр өөрчлөгдсөнийг тусгав.

Харин агуулгын нарийн өөрчлөлтийг улс төр болоод эрх зүйн талаас судлаачид маш олон

хэвлэл мэдээлэл, судлаачдын дунд ч авторитари дэглэм улам бүр багжиж¹⁴ байгаа тухай тайлбарыг дагуулсан юм. Үнэхээр л ганцхан хоногийн өмнө энэ заалтыг нэмэлтээр оруулж, түргэн хугацаанд парламентаар баталж, дараагийн шатны бүх нийтийн санал асуулгад багцлан шилжүүлж байгаа нь урьдаас бэлтгэсэн “тавилт” гэж харагдахаар байлаа.

янзаар тайлбарладаг тул агуулгыг илүү нарийвчлан, улс төр, эрх зүйн чиглэлийн судлаачдын байр суурийг харгалзаж үзлээ.

ОХУ-ын төрийн эрх мэдлийг ОХУ-ын Ерөнхийлөгч, Холбооны Хурал (Холбооны Зөвлөл, Төрийн Дум), ОХУ-ын Засгийн газар, ОХУ-ын Шүүх хэрэгжүүлэх¹⁵ ба энэ удаагийн ҮХ-ийн өөрчлөлтөөр төрийн эрх мэдэл хэрэгжүүлэх байгууллагуудын хүрээнд багагүй өөрчлөлт хийгдсэн нь илэрхий харагдаж байна.

Өөрчлөлтүүдийн¹⁶ дийлэнх нь төрийн эрх мэдэл хуваарилалт, үүрэг хариуцлага шилжихтэй холбоотой, бусад нь ОХУ-ын ҮХ-ийг дээдлэх болон бусад нийгэм, соёл, үнэт зүйлстэй холбоотой. Эдгээрийг агуулгаар нь гурван хэсэг болгон багцалж, эерэг ба сөрөг үр дагаврыг

13 Как Владимир Путин двадцать лет менял российскую Конституцию 2021.04.15 https://www.kommersant.ru/doc/4302515?from=doc_vrez

14 «Обнуляй» и властью: Основные вызовы политическому режиму после 2020 года, Андрей Колесников, Денис Волков, <https://carnegie.ru/2020/12/04/ru-pub-83338>;

15 Новый текст Конституции РФ с поправками 2020, Глава 1, Статья 11. <http://duma.gov.ru/news/48953/>

16 СРАВНИТЕЛЬНАЯ ТАБЛИЦА действующей Конституции Российской Федерации с учетом одобренного закона Российской Федерации «О поправке к Конституции Российской Федерации» «О совершенствовании регулирования отдельных вопросов организации и функционирования публичной власти» <http://duma.gov.ru/media/files/WRg3wDzAk8hRCRoZ3QUGbZ84p10ppmjF.pdf>




График №1 ОХУ-ын ҮХ-ийн өөрчлөлт

(Энэ графикаас зөвхөн хэлбэрийн хувьд ОХУ-ын ҮХ-ийн текст хэр өөрчлөгдсөнийг л харах боломжтой ба агуулгын өөрчлөлт харагдахгүй гэдгийг анхаарна уу)

- шинээр нэмэгдсэн зүйл, заалтыг 4;
- бүхэлд нь өөрчилсөн зүйл, заалтыг 3;
- өгүүлбэр нэмэгдсэн/өөрчилсөн заалтыг 2;
- нэг үг нэмсэн/хассан бол 1 гэсэн нэгжээр тус тус тэмдэглэв.

судалж үзлээ. Үүнд:

1. Төрийн эрх мэдлийн хуваарилалт

Парламентын эрх мэдэл өссөн, Шүүх засаглалыг илүү хараат бус болгосон, төрийн эрх мэдэл хэрэгжүүлэгч байгуулагуудын уялдаа холбоо улам бүр сайжирч буй тухай дээд түвшинд яригдаж байсан хэдий ч гол өөрчлөлтүүд ерөнхийлөгчийн эрх мэдэл тэлэхтэй холбогдлоо.

Ерөнхийлөгч-ийн эрх мэдэл улам нэмэгдсэн, мөн одоогийн Ерөнхийлөгч В.Путины 4 удаа энэ албыг хашсаныг “тэглэсэн” гэдэг дээр дэлхий нийтийн анхаарал төвлөрсөн. ҮХ-ийн 3 дугаар бүлгийн 81 дүгээр заалтад “ОХУ-ын Ерөнхийлөгчийн албыг нэг этгээд (дараалан) хоёроос олон удаа хашиж болохгүй” гэдэг хуучин заалтаас “дараалан” гэдэг үгийг хасаад, 3.1 гэсэн заалт¹⁷ нэмсэн нь ихээхэн

17 “Положение части 3 статьи 81 Конституции Российской Федерации, ограничивающее число сроков, в течение которых одно и то же лицо может занимать должность Президента Российской Федерации, применяется к лицу, занимавшему и (или) занимающему должность Президента Российской Федерации, без учета числа сроков, в течение которых оно занимало и (или) занимает эту должность на момент вступления в силу поправки к Конституции Российской Федерации, вносящей соответствующее ограничение, и не исключает для него возможность занимать должность Президента Российской Федерации в течение сроков, допустимых указанным положением”. - “Нэг этгээдийн ОХУ-ын Ерөнхийлөгчийн албыг хашиж болох давтамжийг хязгаарласан ОХУ-ын ҮХ-ийн 3-р бүлгийн 81 дүгээрт заасан заалтыг ОХУ-ын Ерөнхийлөгчийн албыг хашиж байсан ба (эсвэл) хашиж байгаа этгээдийн хувьд ОХУ-ын ҮХ-ийн харгалзах хязгаарлалтыг агуулж буй энэ өөрчлөлт хүчин төгөлдөр болох мөчид түүний энэхүү албыг хашиж байсан ба (эсвэл) хашиж байгаа давтамжийн тоог тооцохгүй хэрэглэх ба тухайн заалтад зөвшөөрсөн давтамжаар түүнд ОХУ-ын

төвөгтэй найруулгатай. Товчхондоо, ирээдүйд ерөнхийлөгчийн албанд нэг хүн хоёроос олон удаа сонгогдох боломжгүй, харин В.Путинд энэ хязгаарлалт үйлчлэхгүй гэсэн үг.

Ерөнхийлөгчийн эрх мэдэл ямар байдлаар нэмэгдсэнийг, ерөнхий сайд болон засгийн газрын эрх мэдэл хэрхэн хумигдаж, шүүх засаглал ерөнхийлөгчөөс илүү хамааралтай болсныг дараагийн хуудсан дахь хүснэгтээс харьцуулан харж болно. Хэдий хүснэгтээс харьцуулан харах боломжтой ч заримыг онцолбол: өмнөх ҮХ-аар Ерөнхийлөгч “Засгийн газрын хуралдаануудад байлцаж болно” гэж

байсан бол энэ удаагийн өөрчлөлтөөр “Ерөнхийлөгч Засгийн газрын үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангана” гэжээ. Үүнээс харахад Ерөнхий сайд зөвхөн танхимын ажлаа зохион байгуулах л үүргээр эрх мэдэл нь хязгаарлагдаж байна. Мөн Ерөнхий сайд огцорсон тохиолдолд танхим бүхлээрээ огцрохооргүй болсон, дараагийн ерөнхий сайд томилогдож ирээд ямар нэг шинэ хөтөлбөр санал болгох эрхгүй, зөвхөн өмнө явуулж байсан ажил, хөтөлбөрийг үргэлжүүлэх болжээ. Энэ нь Засгийн газрын багаар ажиллах хичээл чармайлтыг үгүй болгож байгаа мэт.

ОХУ-ын Ерөнхийлөгч	
Өмнөх ҮХ	2020 оны ҮХ
2024 оны сонгуульд нэр дэвших эрхгүй	2024 оны сонгуульд нэр дэвших эрхтэй
Нэр дэвшигч 10 жил Орост амьдарсан байх	Нэр дэвшигч 25 жил Орост амьдарсан байх, гадаадын аль нэг улсын банканд хадгаламж, эзэмшилгүй байх
Ерөнхий сайдад нэр дэвшигчийг Төрийн Дум 3 удаа буцаасан тохиолдолд парламентын доод танхимыг тарааж, Төрийн Думын сонгуулийг дахин зарлана.	Ерөнхий сайдад нэр дэвшигчийг Төрийн Дум 3 удаа буцаасан тохиолдолд парламентын доод танхимыг тарааж, ерөнхий сайдыг өөрөө томилно.
Засгийн газрын хуралдаануудад байлцаж болно. Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорно.	Засгийн газрын үйл ажиллагаанд ерөнхий удирдлагыг гүйцэтгэнэ, засгийн газрын бүрэлдэхүүнийг хэвээр хадгалаад ерөнхий сайдыг чөлөөлж болно.
	Гүйцэтгэх засаглалын холбооны байгууллагуудын удирдлагуудыг томилох, чөлөөлөх
	Ерөнхий прокурор, түүний орлогч, мөн мужийн прокуроруудыг томилох

Ерөнхийлөгчийн албыг хаших боломжийг олгож болно” (Албан ёсны баталгаат орчуулга биш гэдгийг анхаарна уу). Новый текст Конституции РФ с поправками 2020, Глава 3, Статья 81, 3.1. <http://duma.gov.ru/news/48953/>

Төрийн зөвлөлд албан ёсны эрх мэдэл байхгүй, зөвхөн зөвлөлдөх үүрэгтэй.	ҮХ-ийн шинэ байгууллага Төрийн Зөвлөлийг Ерөнхийлөгч бүрдүүлнэ.
	Ерөнхийлөгч асан хүн насаараа Холбооны Зөвлөлийн гишүүн байх эрхтэй.
	Ерөнхийлөгч асан хүн халдашгүй дархан байх эрхтэй.
Төрийн Дум	
	Ерөнхий сайдад нэр дэвшигчийг батална.
Ерөнхий сайдад нэр дэвшигчийн талаар ерөнхийлөгчид зөвшөөрөл өгдөг.	Хүчний байгууллага, гадаад харилцааныхаас бусад сайд, дэд сайдуудыг баталгаажуулна.
	Ерөнхийлөгч асан хүний халдашгүй дархан байдлыг цуцлахаар буруутгаж болно.
Холбооны Зөвлөл	
	Ерөнхийлөгчийн томилсон 30 хүртэлх хүн Холбооны Зөвлөлд орно. 7 нь насаараа гишүүн болж болно.
Ерөнхий прокурор, түүний орлогч, мужийн прокуроруудад нэр дэвшигчдийг батлах зөвшөөрөл өгдөг.	Ерөнхий прокурор, түүний орлогч, мужийн прокуроруудад нэр дэвшигчдийн талаар ерөнхийлөгчтэй зөвлөлдөнө.
Шүүх тогтолцоо	
Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн тоо 19	ҮХ-ийн шүүхийн шүүгчдийн тоо 11
Ерөнхийлөгч ҮХ-ийн шүүх, Дээд Шүүх, хяналтын ба давж заалдах шатны шүүгчдийн бүрэн эрхийг зогсоох асуудлыг шүүх өөрсдөө шийддэг.	Ерөнхийлөгч ҮХ-ийн шүүх, Дээд Шүүх, хяналтын ба давж заалдах шатны шүүгчдийн бүрэн эрхийг дуусгавар болгохыг Холбооны зөвлөлд санал болгож болно.
	Хуулиудыг ҮХ-д нийцсэн эсэхийг Үндсэн хуулийн шүүх хянах зөвхөн ганц тохиолдол бий. Дотоодын бүх шатны шүүх шийдвэрлэх боломжгүй гэсэн тохиолдолд Оросын иргэдийн гаргасан гомдлын дагуу хянаж болно.
	Ерөнхийлөгчийн хүсэлтээр хуулиудын төслийг батлагдахаас өмнө, мөн ОХУ-ын субъектүүдийн хуулиуд ҮХ-тай зөрчилдөөгүй эсэхийг хянах ёстой.

Төрийн Зөвлөл нь ҮХ-ийн нэг байгууллага болж, үүнийг ерөнхийлөгч бүрдүүлэх тухай заалт орсон. Төрийн Зөвлөлийн үйл ажиллагааг тусдаа хуулиар тодорхойлно гэж ҮХ-д дурдсан байдаг бөгөөд энэ хууль 2020 оны 12 сарын 19-нд батлагдсан. “Төрийн Зөвлөл эрхийнхээ хүрээнд улсын дотоод ба гадаад бодлогын зорилго, стратегийг боловсруулахад, ОХУ, түүний субъектүүд, орон нутгийн нэгжүүдийн нийгэм-эдийн засгийн салбарын бодлогыг тодорхойлох хэлбэрээр оролцож, Оросын иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор төрийн удирдлагын нэгдсэн тогтолцоонд багтах байгууллагуудын хамтын ажиллагаа, хоорондын зохилдлогот үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ”¹⁸ гэдгээс энэ байгууллагын үүргийг харж болох бөгөөд бүтэц, нарийн үйл ажиллагааг ҮХ-д нарийн тусгаагүй, хожим 2020 оны сүүлээр жич батлагдсан тул энд дэлгэрүүлсэнгүй.

ҮХ-ийн бүтцэд шинээр орсон Төрийн Зөвлөл мөн нэлээд шүүмжлэл дагуулсан юм. Төрийн Зөвлөлийг ҮХ-аар баталгаажуулахдаа зөвхөн 3 дугаар бүлэгт дурдах биш, харин ҮХ-ийн тогтолцооны үндэсийг

тодорхойлсон хэсэгт бичигдэх ёстой тул ҮХ-ийг зөрчиж буй хэрэг гэж Германы эрдэмтэн Каролине фон Галл тайлбарласан¹⁹ байна. Үнэхээр 9 дүгээр бүлгийн 135 дугаар зүйлийн 2-т: хэрэв 1,2 болон 9 дүгээр бүлэгт өөрчлөлт оруулах бол ҮХ-ийн хуралдааныг холбооны ҮХ-ийн хуулийн (федеральный конституционный закон) дагуу зарлах ёстой гэж заасан байдаг. Судлаачийн зүгээс, Төрийн Зөвлөлийг ҮХ-ийн байгууллагуудын бүтцэд оруулж ирэхдээ тусдаа бүлэг болгохгүй, 3 дугаар бүлэг – Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд багтааснаар гол хуулийг зөрчөөгүй гэж тайлбарлаж болох юм.

Барууны хэвлэл мэдээллийн хэрэгсэлд дараагийн сонгуульд В.Путины нэр дэвших эрх нээгдэж байгааг эерэг талаас нь тайлбарласан нийтлэл байхгүй, эрх зүйч, улс төрчид нэлээд шүүмжтэй байр сууринаас хандаж байсан хэдий ч энэ асуудал бол улс орны дотоод асуудал юм. Харин БНХАУ-ын Гадаад хэргийн яамны албан ёсны төлөөлөгч Чжао Лицзянь “Оросын иргэдийн хийсэн хөгжлийн зам ба сонголтыг хүндэтгэх болно”²⁰ гэдгээ илэрхийлж байлаа.

18 Государственный Совет Федеральный закон от 8 декабря 2020 года №394-ФЗ «О Государственном Совете Российской Федерации» <http://www.kremlin.ru/structure/state-council>

19 Западные эксперты о поправках Путина: Грубое нарушение Конституции РФ <https://www.dw.com/ru/%D0%B7%D0%B0%D0%BF%D0%B0%D0%B4%D0%BD%D1%8B%D0%B5-%D1%8D%D0%BA%D1%81%D0%BF%D0%B5%D1%80%D1%82%D1%8B-%D0%BE-%D0%BF%D0%BE%D0%BF%D1%80%D0%B0%D0%B2%D0%BA%D0%B0%D1%85-%D0%BF%D1%83%D1%82%D0%B8%D0%BD%D0%B0-%D0%B3%D1%80%D1%83%D0%B1%D0%BE%D0%B5-%D0%BD%D0%B0%D1%80%D1%83%D1%88%D0%B5%D0%BD%D0%B8%D0%B5-%D0%BA%D0%BE%D0%BD%D1%81%D1%82%D0%B8%D1%82%D1%83%D1%86%D0%B8%D0%B8-%D1%80%D1%84/a-52101758>

20 МИД КНР: Китай уважает выбор россиян на голосовании по поправкам к Конституции РФ, 2 июля 2020 <https://tass.ru/mezhdunarodnaya-panorama/8867801>

2. ОХУ-ын Үндсэн хууль vs олон улсын гэрээ

Олон улсын байгууллагын зарим шийдвэрийг оросын төр засаг хэрэгсэхгүй байх тухай ҮХ-ийн 79 дүгээр зүйлд нэмэлт өөрчлөлт оруулсан. Тухайн заалтаар бол ОХУ-ын ҮХ-тай зөрчилдөж байгааг ОХУ-ын ҮХ-ийн шүүх хүлээн зөвшөөрсөн тохиолдолд олон улсын байгууллагаас гаргасан тухайн шийдвэрийг биелүүлэхгүй байхыг зөвшөөрчээ. Гэхдээ олон улсын гэрээ оросын хуулиас давуу гэдэг заалт хүчинтэй хэвээр.

Мөн энэ зүйлд шинэ дэд заалт нэмж оруулсан нь “ОХУ нь олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, дэмжихэд, улс орон ард түмнүүдийн энх тайвнаар зэрэгцэн оршиход, улс орны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцуулахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэжээ. Энэ заалтын тухайд бас маргаан дагуулж байна. Учир нь олон улсын гэрээ болон ОХУ-ын ҮХ-ийн харилцан үйлчлэлийг тодорхойлдог 1 дүгээр бүлгийн 15 дугаар зүйлд²¹ өөрчлөлт оруулах ёстой, харин “79 дүгээр зүйлд олон улсын гэрээ хэлэлцээрүүд ОХУ-ын ҮХ-тай

зөрчилдсөн тохиолдолд ОХУ үүнд хэрхэн нэгдэх тухайд яригддаг”²² гэж германы эрдэмтэн Отто Лухтерхандт²³ тайлбарлажээ. Энэ заалтын өөрчлөлт нь ирээдүйн хууль дүрмийн тухай биш, харин одоо үйлчилж байгаа гэрээ хэлэлцээрүүдтэй холбоотой болж байна.

3. Бусад өөрчлөлт

Ерөнхийлөгч В.Путины 2020 оны Илгээлтэд төрийн эрх мэдлийн хуваарилалт, ерөнхийлөгчийн сонгуульд түүний нэр дэвших эрх үүсэх гэхээсээ илүүтэй бусад эдийн засаг нийгмийн асуудал, хүн амын тэтгэврийн индексжүүлэлт, нутгийн өөрийн удирдлага, парламентын эрхийг нэмэгдүүлэх гэх мэт бусад асуудлууд хамгийн чухлаар тавигдаж байсан ч ҮХ-нд өөрчлөлт хийсний дараа дээр дурьдсан асуудлууд жин дарсангүй, дагавар шинжтэй орсон. Эдгээр өөрчлөлтүүдийг товч дурьдвал:

- Нутгийн өөрийн удирдлагын байгууллагууд, төрийн эрх мэдлийн байгууллагууд нэгдсэн төрийн удирдлагын тогтолцоонд орж, харилцан үйл ажиллагаа явуулах болсныг;

21 15.4. ОХУ-ын олон улсын гэрээ эрх зүйн бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ нь түүний эрх зүйн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг юм. Хэрэв ОХУ-ын олон улсын гэрээнүүдэд хуулиар өмнө нь заагаагүй өөр дүрэм тогтоовол олон улсын гэрээний дүрмийг хэрэглэнэ (Судл.) Новый текст Конституции РФ с поправками 2020, Глава 1, Статья 15.4 <http://duma.gov.ru/news/48953/>

22 Что не так с поправками Путина в Конституцию РФ <https://www.dw.com/ru/%D0%B7%D0%B0%D0%BF%D0%B0%D0%B4%D0%BD%D1%8B%D0%B5-%D1%8D%D0%BA%D1%81%D0%BF%D0%B5%D1%80%D1%82%D1%8B-%D0%BE-%D0%BF%D0%BE%D0%BF%D1%80%D0%B0%D0%B2%D0%BA%D0%B0%D1%85-%D0%BF%D1%83%D1%82%D0%B8%D0%BD%D0%B0-%D0%B3%D1%80%D1%83%D0%B1%D0%BE%D0%B5-%D0%BD%D0%B0%D1%80%D1%83%D1%88%D0%B5%D0%BD%D0%B8%D0%B5-%D0%BA%D0%BE%D0%BD%D1%81%D1%82%D0%B8%D1%82%D1%83%D1%86%D0%B8%D0%B8-%D1%80%D1%84/a-52101758>

23 Отто Лухтерхандт бол 1993 онд ОХУ-ын Үндсэн хуулийг боловсруулахад зөвлөхөөр оролцож байсан, ОХУ-ын хууль эрх зүйн асуудлаар нарийн мэргэшсэн судлаач, эрх зүйч юм.

- Тэтгэврийн доод хэмжээг индексжүүлэх тухай;
- ОХУ бол ЗХУ-ын хууль ёсны залгамжлагч мөн болох тухай;
- Бурханд итгэх итгэлийн тухай;
- Хүүхдүүд Оросын төрийн бодлогод хамгийн чухал тэргүүнд тавигддаг болсон тухай;
- Хүүхдүүдийг ахмадаа хүндэтгэх, эх оронч үзлээр хүмүүжүүлэх тухай;
- ОХУ, түүний субъектүүдэд эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийлсэн уламжлалт гэр бүлийг хамгаалах тухай;
- Орос хэл бол төрт улсыг бүрдүүлэгч ард түмний хэл гэдгийг;
- Эх орноо хамгаалсан ард түмний үйл хэргийн мөн чанарыг дорд үзэх явдлыг гаргуулахгүй төдийгүй Орос Улс түүхэн үнэнийг хамгаална гэдгийг тус тус нэмэлтээр оруулжээ.

Эдгээрээс чухалчилмаар хоёр заалтыг дурьдвал, *нэгдүгээрт*, дотоод бодлогын хувьд, нутгийн өөрийн удирдлагын эрх мэдлийн асуудал. Нутгийн өөрийн удирдлага нэгдсэн төрийн удирдлагад нэгдэж байгаа явдал нь ОХУ-ын субъектүүдийн бие даасан байдал улам бүр хумигдаж, төвлөрсөн төв удирдлагаас улам бүр хараат болж байна. *Хоёрдугаарт*, гадаад бодлогын хувьд, ОХУ нь ЗХУ-ын хууль ёсны залгамжлагч мөн гэдгийг тодотгож өгсөн явдал юм. ОХУ нь ЗХУ-ын “өөрийн нутаг дээрх” хууль ёсны угсаа залгамжлагч, мөн

олон улсын байгууллагын гишүүнчлэл, гэрээ хэлэлцээрүүдтэй холбоотой харилцаанд ОХУ-ын нутаг дэвсгэрээс гаднах хуучин ЗХУ-ын хууль ёсны залгамжлагч юм гэснээс харахад, ОХУ нь гадаад бодлогоо явуулахдаа зөвхөн өнөөгийн ОХУ-ын байр сууринаас төдийгүй, хуучин ЗХУ-ын нутаг дэвсгэрт ашиг сонирхол нь хөндөгдөх эсэхэд ихээхэн анхаарал хандуулна гэдгээ хуульчилж өгчээ.

Харин хүүхэд төрийн бодлогын тэргүүнд тавигдах, ахмадаа хүндэтгэж хүмүүжүүлэх, эрэгтэй, эмэгтэй хүмүүс зөвхөн гэр бүлд тооцогдох, Бурханд итгэх тухай заалтуудын ҮХ-д оруулж өгсний нарийн утга учир, тайлбарыг тодорхойлох нь багагүй цаг хугацааны асуудал болов уу. Харин тэтгэврийг индексжүүлэх тухай заалт бол нийгмийн асуудлыг тодорхой хэмжээгээр шийдэж, ард түмний саналд эергээр нөлөөлөх гэсэн нэг үйлдэл юм.

Ерөнхийдөө анх дэлгэж тавьсан хэрэгцээ шаардлагад аливаа үндсэн хуулийн гол тулгууруудын нэг болох иргэдийн эрх эрх чөлөө, сайн сайхан аж амьдралын баталгаа болсон нийгмийн асуудлыг шийдэх, хүн амын амьжиргааг сайжруулахад төвлөрч байсан бол ажил хэрэг болж батлагдсан өөрчлөлтүүдийг харахад төрийн эрх хэрэгжүүлэгч байгууллагуудын эрх мэдэл хуваарилалт жин дарсан шийдэл боллоо.

Дүгнэлт

ОХУ-ын ҮХ-ийн энэ удаагийн өөрчлөлт дэлхий нийтийн анхаарлыг ихээхэн татаж, одоогийн ерөнхийлөгчийн төрийн өндөрлөгт байх хугацаа, эрх мэдлийн тэлэлт, хүний эрхийн асуудал, ОХУ-ын ҮХ олон улсын гэрээ эрх зүйгээс дээгүүр тавигдах тухай өөрчлөлт дээр төвлөрлөө. Гэвч зөвхөн ерөнхийлөгч өөрийн эрх мэдлийг авч үлдэхийн төлөө ийм алхам хийж байна гэж дүгнэх нь хэт нэг талыг баримталсан тайлбар болох юм.

Ерөнхийлөгчийн 2020 оны Илгээлтээс харахад энэхүү өөрчлөлт нь нэг талаас тус улсын нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын дотоод хүчин зүйлээс, нөгөө талаас аюулгүй байдал, тусгаар тогтнолоо бататгах, бусад улс орон, олон улсын байгууллагын зүгээс улс орны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцуулахгүй байх гэсэн эрмэлзэл, хүчин зүйлээс шалтгаалан хийгдэж байна гэж болохоор байсан. Харин бодитоор ҮХ-ийн өөрчлөлтийг нягтлан үзвэл нийгэм, соёл, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх талын гэж болохуйц шинэчлэлтүүд нь төрийн эрх мэдэл хуваарилалтад хийгдэж байгаа өөрчлөлтүүдэд дарагдан, голлох байр суурь эзлэхгүй, дагалдах

төдий шийдвэр мэт харагдаж байна. Хамгийн гол өөрчлөлт төрийн эрх мэдэл хэрэгжүүлэгч байгууллагуудын эрх мэдлийн хуваарилалт дээр төвлөрч, ялангуяа ерөнхийлөгчийн эрх мэдэл мэдэгдэхуйц нэмэгдсэн, засгийн газрын эрх мэдэл хумигдсан, ерөнхий сайдын үүрэг зөвхөн ажил зохион байгуулах төдийхнөөр хязгаарлагдах болсон, шүүх засаглал ерөнхийлөгчөөс илүү хараат болж ардчиллын зарчим алдагдаж, авторитари шинжтэй болж байна.

ОХУ нь гадаад ба олон улсын аюулгүй байдлын нөхцөл байдлыг дүгнэх өнцгөө өөрчилж, В.Путины Илгээлтэд өгүүлснийг хоёр чиглэлд тусгасан. *Нэгдүгээрт*, Үндсэн хуулиа олон улсын гэрээ эрх зүйгээс дээгүүр тавьснаар Үндсэн хуулийн ач холбогдлыг өсгөсөн. *Хоёрдугаарт*, ОХУ-ын одоогийн нутаг дэвсгэр, ЗХУ-ын хуучин орон зайд ашиг сонирхлоо хөндүүлэхгүй байх зарчим баримталж байгаагаа хуульчилж, дэлхийн бодлогод эргэн ирж байгаагаа илэрхийллээ.

Харин үнэт зүйл, соёл, бурхан, гэр бүл, хүүхэд, хүүхдийн хүмүүжлийн талаар оруулсан өөрчлөлтүүдийн үр нөлөөг үнэлэх, дүгнэх хараахан болоогүй болов уу.

Ашигласан материал

1. Послание Президента Федеральному Собранию. 15 января 2020 года, 13:15, Москва. <http://kremlin.ru/events/president/news/62582>
2. Новый текст Конституции РФ с поправками 2020, Глава 1, Статья 11. <http://duma.gov.ru/news/48953/>
3. Конституционное право зарубежных стран
4. СРАВНИТЕЛЬНАЯ ТАБЛИЦА действующей Конституции Российской Федерации с учетом одобренного закона Российской Федерации «О поправке к Конституции Российской Федерации» «О совершенствовании регулирования отдельных вопросов организации и функционирования публичной власти» <http://duma.gov.ru/media/files/WRg3wDzAk8hRCRoZ3QUGbZ84pI0ppmjF.pdf>
5. ОХУ-ын Төрийн Думын цахим хуудас, Государственный Совет Федеральный закон от 8 декабря 2020 года №394-ФЗ «О Государственном Совете Российской Федерации» <http://www.kremlin.ru/structure/state-council>
6. ОХУ-ын Төрийн Зөвлөлийн цахим хуудас <http://www.kremlin.ru/structure/state-council>
7. Московский центр карнеги <https://carnegie.ru>
8. Мэдээллийн TASS цахим хуудас, <https://tass.ru/mezhdunarodnaya-panorama>
9. Мэдээллийн DW цахим хуудас www.dw.de
10. Независимая газета <https://www.ng.ru>
11. Коммерсант <https://www.kommersant.ru>
12. Tagesspiegel <https://www.tagesspiegel.de>
13. New York Times <https://www.nytimes.com>

The amendments to the Constitution of Russia: factors influencing the constitutional changes and reflections on the Constitution

Tuul Damba-Ochir

*Institute of International Affairs, Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar, Mongolia
tuul_d@mas.ac.mn*

Abstract: *The amendments to the Constitution of Russia involve more than forty articles, which oversee the separation of powers, broaden the powers of both houses of parliament, legitimize the State Council as official body of the state, emphasize the primacy of Russian law over international norms, legalize a guaranteed minimum pension and family values. However, politics and jurists globally note that the core of this constitutional changes could pave the way for Vladimir Putin to broaden his power and serve a third consecutive term as the president under the new rules. Therefore, it is necessary to analyze, how the foreign and domestic political factors of Russia influence on the constitutional changes and how the original proposals of president V. Putin are reflected in the new constitution. This paper explores on explanations and analyses stances of politics and jurists of Russia and the West, and gives researcher's own opinion on changes of the amendments to the Constitution of Russia.*

Keywords: *Russia, Constitution, The amendments to the Constitution of Russia, V. Putin, separation of power, power of president*

<i>The day of submission:</i>	2021.06.14
<i>Completion of review:</i>	2021.06.17
<i>Final decision for acceptance:</i>	2021.07.01